

“ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ТАВ” ОНӨААТҮГ

2024 оны 10 дугаар сарын 02-ны өдөр

ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ МАТЕРИАЛ ХУДАЛДАН АВАХ  
БАРАА НИЙЛҮҮЛЭХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалтын нэр:  
Тендер шалгаруулалтын дугаар:

Цэвэрлэгээний материал  
3TT/20240018

Улаанбаатар

2024 он

## **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА**

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА .....	3
II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ .....	10
III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА .....	14
IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ .....	25
V БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ .....	28

# I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

## A. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

<b>1. Тендерийн цар хүрээ</b>		<p>1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгт (цаашид “ӨХ” гэх)-д заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон бараа, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “бараа” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтын баримт бичгийг гаргаж байна. Зарлалын дугаар, тендер шалгаруулалтын нэр, дугаар, багцын мэдээлэл өгөгдлийн хүснэгтэд бичигдэнэ.</p>
<b>2. Санхүүжилтийн үүсвэр</b>	<b>эх</b>	<p>2.1. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр, төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.</p>
<b>3. Худалдан ажиллагааны тогтоомж</b>	<b>авах хууль</b>	<p>3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.</p> <p>3.2. Худалдан авах ажиллагаанд захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.</p> <p>3.3. Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20<sup>1</sup>, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй.</p>
<b>4. Оролцогч, сонирхогч этгээдэд тавигдах ерөнхий шаардлага</b>		<p>4.1. Оролцогч хуулийн 7.1.1-7.1.9-д заасан нөхцөлийг хангасан байна.</p> <p>4.2. Түншлэлээр оролцох тохиолдолд түншлэлийн гишүүн бүр ерөнхий шаардлага хангасан байна.</p> <p>4.3.. Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно.</p> <p>4.4. Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.</p> <p>4.5. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.</p>
<b>5. Туслан гүйцэтгэгч</b>		<p>5.1. Хуулийн 6.4-т зааснаар тендерийн үнийн 20 хүртэл хувьтай тэнцэх гүйцэтгэлийг нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдээр туслан гүйцэтгүүлэх тохиолдолд туслан гүйцэтгэх үүргийг гэрээнд заасан байна.</p> <p>5.2. Туслан гүйцэтгүүлэх хувь хэмжээ тендерийн үнийн 20 хувиас хэтэрсэн, эсхүл туслан гүйцэтгүүлэх тоо хэмжээг заагаагүй бол туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.</p> <p>5.3. Туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсэн болохыг туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.</p>
<b>6. Бараанд тавигдах ерөнхий шаардлага</b>		<p>6.1. Дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой чанар, стандартын шаардлага хангасан бараа худалдан авахаас,</p>

		эсхүл хууль тогтоомжоор барааны гарал үүслийг заавал нотлохоос бусад тохиолдолд оролцогч аль ч улсын гарал үүсэлтэй бараа санал болгож болно.
7.Худалдан ажиллагааны систем	авах цахим	6.2.Харьцуулалтын аргаар худалдан авах бараа Сангийн сайдын баталсан “Бүртгэл хөтлөх, мэдээллийг баталгаажуулах журам”-ын дагуу хуулийн 4.1.25-д заасан цахим катологид бүртгэгдсэн байна.
8.Тендер шалгаруулалтын баримт бичгийн бүрдэл		7.1.Харьцуулалтын аргаар ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем ( <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> ) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.
9.Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах		<b>Б.АГУУЛГА</b> 8.1.Тендер шалгаруулалтын баримт бичиг дараах бүлэг болон түүний нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ. I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа; II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт; III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага, бараа нийлүүлэлтийн хуваарь; IV Бүлэг. Тендерийн жишиг маягт; V Бүлэг. Гэрээний нөхцөл. 8.2.Тендер шалгаруулалтын зарлал, цахим системээр хүргүүлсэн урилга нь тендер шалгаруулалтын баримт бичгийн бүрдэл болохгүй. 8.3.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд нийцүүлэн тендер бэлтгэнэ.
10.Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах		9.1.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно. 9.2.Тодруулга авах хүсэлтийг өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна. 9.3.Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана. 9.4.Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн тооцно. 9.5.Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 10-д заасныг мөрдөнө. 10.1.Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно. 10.2.Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно. 10.3.Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн

**11.Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт**

хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.

11.1.Захиалагч сонирхогч этгээдийн тендер бэлтгэхтэй холбоотой асуултад хариулт өгөх уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол өгөгдлийн хүснэгтэд заана.

11.2.Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцно.

11.3.Уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.

**В.ТЕНДЕР БЭЛТГЭХ****12.Тендер шалгаруулалтын хэл**

12.1.Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

12.2.Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа худалдан авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

12.3.Хэрэв ТШЗ-ны 12.2-т заасан тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.

12.4.Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

13.1.Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

13.1.1.TШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

13.1.2.Тендерийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

13.1.3.TШЗ-ны 15-т заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

13.1.4.TШЗ-ны 16-т заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

13.1.5.Бараа нийлүүлэлтийн хуваарь;

13.1.6.Санал болгож буй бараа ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;

13.1.7.TШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;

13.1.8.TШЗ-ны 22.5-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;

13.2.Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

<b>14.Тендерийн маягт</b>	<b>жишиг</b>	14.1.IV бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.
<b>15.Хувилбарт санал</b>		15.1. Хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг ирүүлэх шаардлагатай бол өгөгдлийн хүснэгтэд заана.
<b>16.Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг</b>		16.1.ТШЗ-ны 14.1-д заасны дагуу бөглөж ирүүлсэн V бүлгийн Маягт 1. 16.2.Хэрэв өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 7.1-д заасан ерөнхий нөхцөлийг магадлахтай холбоотой баримт бичиг. 16.3.Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.
<b>17.Чадавхын болон туршлагын шаардлага тавих үндэслэл</b>		17.1.ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тавихад хуулийн 15 дугаар зүйлийг баримтална. 17.2.Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй. 17.3.Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.. 17.4.Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.
<b>18.Санхүүгийн чадавхын шаардлага</b>		18.1.Хуулийн 16.5-д зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага хангасан байна. 18.2.Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. 18.3.Оролцгчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкнаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцгчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй. 18.4.Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойши хөдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгуулагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.
<b>19.Техникийн чадавх болон туршлагын шаардлага</b>		19.1.Хуулийн 17.4-т зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна. 19.2.Техникийн болон туршлагын чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах бол хуулийн 17.2-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. 19.3.Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана.

<b>20.Санал болгож буй бараанд тавигдах шаардлага</b>	<p>20.1.ТШЗ-ны 6.1-д заасан тохиолдолд импортын барааны гарал үүслийг нотлох баримт бичиг тендерт ирүүлэхийг шаардахгүй.</p> <p>20.2.Санал болгож буй барааны техникийн тодорхойлолтод нийцсэн болохыг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.</p> <p>20.3.Нотлох баримт нь нийтлэл, зураг, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас хэлбэрээр байж болно.</p> <p>20.4.Хэрэв санал болгох бараа техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй боловч шаардлага хангах бол түүнийг нотлох шаардлагатай.</p>
<b>21.Санал болгож буй барааны нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээ</b>	<p>21.1.Санал болгож буй барааны нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээтэй холбоотой өгөгдлийн хүснэгтэд заасан бол дараах баримт бичиг, мэдээллийг ирүүлнэ. Үнд:</p> <p>21.1.1.санал болгож буй барааг тасралтгүй, горимын дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан хугацаанд ашиглахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалт, авах боломжтой хаяг, тэдгээрийн үнийн мэдээлэл;</p> <p>21.1.2.засвар, үйлчилгээг хэрхэн үзүүлэх тухай баримт болон мэдээлэл.</p> <p>21.1.3.гадаадын этгээдийн хувьд нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг үзүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрөө, эсхүл өөрийн Монгол Улсад байгуулсан буюу байгуулах салбар, төлөөний газар, эсхүл бусад төлөөлөгч гүйцэтгэх тухай баримт.</p>
<b>22.Тендериийн үнэ</b>	<p>22.1.Унийн санал дуудах ажиллагаа хаагдахад санал болгосон үнэ оролцогчийн тендериийн үнэ байна.</p> <p>22.2.Тендериийн үнэ гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх эсэхийг өгөгдлийн хүснэгтэд заана. Өгөгдлийн хүснэгтэд тогтмол байхаар заасан тохиолдолд тохируулга хийх нөхцөлтэй тендер ирүүлсэн бол шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.</p> <p>22.3.Бараа нийлүүлэх тендерт Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргадаг Олон улсын худалдааны нөхцөл /Incoterms/-ийг хэрэглэхдээ өгөгдлийн хүснэгтэд заагаагүй бол хамгийн сүүлийн хувилбарын Delivery Duty Paid /DDP/ нөхцөлийг бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.</p> <p>22.4.Унийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендериийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.</p> <p>22.5.Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендериийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.</p> <p>23.1.Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендериийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай</p>
<b>23.Тендериийн валют</b>	

		хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлнэ.
<b>24.Тендер хүчинтэй байх хугацаа</b>		24.1.Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар тендер илгээх маягтад заана. 24.2.Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 24.1-д заасан хугацааг сунгаж болно. 24.3.Оролцогч хугацааг сунгасан бол хуулийн 28.9-д зааснаар бичгээр мэдэгдэнэ.
		<b>Г.ТЕНДЕР ИЛГЭЭХ</b>
<b>25.Тендер баталгаажуулах, илгээх</b>		25.1.Тендерийг хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу баталгаажуулан илгээнэ. 25.2.Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол IV бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй. 25.3.Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг IV бүлгийн Маягт 5-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ. 25.4.Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.3-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэлд хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.
<b>26.Тендер хүлээн авах эцсийн хугацаа</b>		26.1.Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.
		<b>Д.ҮНИЙН САНАЛ ДУУДАХ АЖИЛЛАГАА</b>
<b>27.Үнийн санал дуудах хугацаа</b>		27.1.Хуулийн 34.6-д зааснаар үнийн санал дуудах ажиллагаанд бүртгүүлсэн сонирхогч этгээдийн тоо зарлалд заасан шаардлагатай тоонд хүрсэн тохиолдолд уг ажиллагаа ТШЗ-ны 26.1-д товлосон хугацаанаас нэг цагийн дотор эхэлнэ. 27.2.Үнийн санал дуудах ажиллагаа хуулийн 34 дүгээр зүйлд заасан журмын дагуу явагдана. 27.3.ТШЗ-ны 27.2-т заасан ажиллагаа урилгад заасан хугацаанд үргэлжилж хаагдана.
<b>28.Тендер нээх</b>		28.1.ТШЗ-ны 27.3-т зааснаар хугацаа хаагдахад цахим систем оролцогч нарын санал болгосон эцсийн үнийг өсөх дарааллаар эрэмбэлэх ба захиалагч зөвхөн эхэнд эрэмбэлэгдсэн оролцогчийн тендерийг нээнэ.
		<b>Е.ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ /ХЯНАН ҮЗЭХ</b>
<b>29.Тендерийг шаардлагад нийцэх эсэхийг хянан үзэх</b>		29.1.Нээсэн тендерийг хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 13-т заасан тендерийн бурдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн Сангийн сайдын баталсан зааврын дагуу хянан үзнэ.

		29.2.Тендерт ирүүлсэн аливаа баримт бичгийн үнэн зөв, хүчинтэй байдлыг шалгаж үзэх эрхтэй байна.
		29.3.Эхэнд эрэмбэлэгдсэн оролцогчийн тендер шаардлагад нийцээгүй бол удаах эрэмбэлэгдсэн тендерийг хянан үзнэ.
<b>30.Тендерийн талаар тодруулга авах</b>		30.1.Тендерийг хянан үзэх явцад тодруулга авах шаардлагатай гэж үзвэл хуулийн 25 дугаар зүйлийг баримтална.
		<b>Ё.МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ</b>
<b>31.Мэдэгдэл хүргүүлэх</b>		31.1.Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэрийг хуулийн 24.1-д зааснаар ажлын 15 өдрийн дотор гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.
<b>32.Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах</b>		32.1.Захиалагч ТШЗ-ны 8.1-д заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ. 32.2.Шалгарсан оролцогч ТШЗ-ны 32.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчийн тогтоосон хугацааны дотор хүргүүлнэ. 32.3.Захиалагч хуулийн 30.4-т зааснаар ажлын 10 өдрийн дотор гэрээг баталгаажуулаагүй бол гэрээ байгуулах шийдвэрт заасан нөхцөлөөр гэрээ байгуулсанд тооцогдоно.
		<b>Ж.БУСАД</b>
<b>33.Үнийн санал дуудах ажиллагааг дахин зарлах</b>		33.1.Захиалагч ТШЗ-ны 29.3-т зааснаар хянан үзээд бүх тендерээс татгалзсан бол шаардлага хангасан тендер ирээгүй шалтгааныг судалж, тендер шалгаруулалтыг дахин зарлах эсэх мэдээллийг хуулийн 28.1.3-т заасан шийдвэрт заана.
<b>34.Тендер шалгаруулалтад гомдол гаргах</b>		33.2.Үнийн санал дуудах ажиллагааг дахин зарлахад хуулийн 34.11-д заасныг баримтална. 34.1.Хууль болон Сангийн сайдын баталсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын дагуу гомдлыг хянан шийдвэрлэнэ.

## II БҮЛЭГ.ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

<b>ТШЗ-НЫХОЛБОГОХЗААЛТ</b>	<b>A.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</b>
<b>ТШЗ 1.1</b>	Захиалагчийн нэр: “Зорчигч тээвэр тав” ОНӨААТУГ
<b>ТШЗ 1.1</b>	Зарлалын дугаар: 3ТТ/2024018 Тендер шалгаруулалтын нэр: Цэвэрлэгээний материал.
<b>ТШЗ 2.1</b>	Санхүүжилтийн эх үүсвэр: Өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.  Нийт төсөвт өртөг: 57,401,400.0 (тавин долоон сая дөрвөн зуун нэг мянга дөрвөн зуу) төгрөг.
<b>Б.АГУУЛГА</b>	
<b>ТШЗ 9.2</b>	Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хаяг:  Хүлээн авагчийн нэр: “Зорчигч тээвэр тав” ОНӨААТУГ. Хаяг: Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Үйлдвэрийн баруун бүс /16100/, ХД- 95-1 тоот, Улаанбаатар хот, Монгол улс, Өөрийн байранд 204 тоот Худалдан авах ажиллагааны алба. Утасны дугаар: 77526666, Цахим шуудангийн хаяг: <a href="mailto:5.zteever@gmail.com">5.zteever@gmail.com</a>
<b>ТШЗ 11.1</b>	Тендер ирүүлэх өмнө уулзалт зохион байгуулах эсэх: “Үзүү”
<b>В.ТЕНДЕР БЭЛТГЭХ</b>	
<b>ТШЗ 12.2</b>	Тендер шалгаруулалтын хэл: Монгол хэл.
<b>ТШЗ 15.1</b>	Хувилбарт санал ирүүлэхийг: “Зөвшөөрөхгүй”
<b>ТШЗ 16.2</b>	Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг:  1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлэх шаардлагагүй бөгөөд “Төрийн мэдээлэл солилцооны ХҮР систем”-ээр дамжуулан шалгана.  2. Тендер шалгаруулалт зарласнаас хойш хугацаанд цахим системээс авсан нийгмийн даатгалын шимтгэлийн болон татварын өр төлбөргүй тодорхойлолтыг цахим системийн холбогдох талбараар зааварчилгааны дагуу тус тус ирүүлнэ. Энэхүү тодорхойлолтыг ирүүлээгүй тохиолдолд тендер нээсэн өдрийн байдлаар татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өр төлбөрийн талаарх мэдээллийг шалгана.  3. Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр, төлбөргүй талаархи хүчин төгөлдөр лавлагааг цахим системээс авч, зааварчилгааны дагуу цахим системээр холбогдох талбараар ирүүлнэ. Анхааруулга: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт авах хүсэлтийг тендерт оролцож Худалдан авах ажиллагааны цахим систем ( <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> )-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлтээс өмнө хүчин төгөлдөр тодорхойлолтыг тендер илгээх холбогдох хэсэгт сонгож цахим хэлбэрээр ирүүлнэ.  4. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай хуульд бусад баримт бичгийг хавсарган ирүүлнэ. Түншлэлээр оролцож буй тохиолдолд түншлэлийн төлөөлөх эрх бүхий этгээд нь түншлэлийн гэрээг цахим системд баталгаажуулсны дараа гишүүн этгээдийн хүчин төгөлдөр тодорхойлолтыг тендер илгээх холбогдох хэсэгт сонгож илгээнэ. Дээрх баримт бичгийг ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзана.
<b>ТШЗ 18.1</b>	Санхүүгийн чадавхын шаардлага:  1. Борлуулалтын орлогын хэмжээ: 2021, 2022, 2023 онуудын борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь батлагдсан төсөвт

	<p>өртгийн 30 хувь болон түүнээс багагүй байна.</p> <ol style="list-style-type: none"> <li>2. Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ: Батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй байна.</li> <li>3. Банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байна.</li> </ol>
ТШЗ 18.2	<p>Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Тендерт оролцогчийн 2021, 2022, 2023 онуудын борлуулалтын орлогын мэдээллийг Сангийн яамны санхүүгийн тайлангийн <a href="http://www.e-balance.mof.gov.mn">www.e-balance.mof.gov.mn</a> мэдээллийн систем дэх санхүүгийн тайлангаас шалгана;</li> <li>- Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдийн лавлагаа;</li> <li>- Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээг нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл нийлбэрээр тодорхойлно.</li> </ul> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Тендерт оролцогчийн харилцагч банкны дансны үлдэгдэл;</li> <li>- Харилцагч банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт;</li> <li>- Үнэт цаас, Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийнтухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд. Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан зээлийн мэдээллийнүйлчилгээ үзүүлэх этгээдээс тендер шалгаруулалт зарласан өдрөөс хойшавсан шалгах боломж бүхий QR кодтой “Зээлийн мэдээллийн лавлагаа”-г тендерт хавсарган ирүүлнэ. Зээлийн ангилал нь “Хэвийн”-ээс бусад ангилалтай тохиолдолд татгалзах үндэслэл болно./Харилцагч банкны тодорхойлолтыг тендерийг хянан үзэхэд харгалzanүзэхгүй./</li> <li>- Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: 2021, 2022, 2023 онууд.</li> </ul>
ТШЗ 19.1	<p>Техникийн чадавх болон туршлага: “<b>Шаардана</b>”</p> <p>Ижил төстэй гэрээний туршлага: “<b>Шаардана</b>”</p> <p>Сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилд доод тал нь нэг удаа батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй бараа нийлүүлсэн байна. Туршлагыг нотлох гэрээний хуулбар, бараа хүлээлцсэн акт гэрээ дүгнэсэн протоколын хувийг тендерт хавсарган ирүүлнэ.</p> <p>Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээ байгаа бол уг гэрээний мэдээлэл ирүүлнэ.</p> <p>Гэрээний үүргийн гүйцэтгэлийг хариуцах ажилтны нэр, боловсрол, мэргэжлийн ур чадварын шаардлага: “<b>Шаардахгүй</b>”</p> <p>Гэрээний үүргийг гүйцэтгэхтэй холбоотой машин механизм, тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн байрны шаардлага: “<b>Шаардахгүй</b>”</p>
ТШЗ 19.2	Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг:

	<ol style="list-style-type: none"> <li>Сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудад ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээллийг жагсаалтаар, тодорхой ирүүлнэ.</li> <li>Захиалагч болон нийлүүлэгчийн техникийн тодорхойлолтыг харьцуулсан байдлаар дэлгэрэнгүй танилцуулга, хүснэгтээр бэлтгэж баталгаажуулан ирүүлнэ.</li> <li>Барааны үнийн задаргаа ба бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу баталгаажуулан ирүүлнэ.</li> <li>Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтаан чанарын шаардлага хангасан барааг захиалагчид нийлүүлэх, баталгааг албан бичгээр гаргаж ирүүлнэ.</li> <li>Нийлүүлэх бараа нь захиалагчийн тогтоосон техникийн тодорхойлолтын шаардлагыг хангаж буйг нотлох зүйл, заалт бүрээр харуулсан тайлбарыг албан мэдэгдлийг баталгаажуулан ирүүлнэ.</li> </ol>
<b>ТШЗ 19.3</b>	<p>Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ шаардлагатай эсэх: <b>“Тийм”</b></p> <p>Үйлдвэрлэгчийн албан ёсны гэрээт борлуулагч, итгэмжлэгдсэн төлөөлөгч байх шаардлагатай.</p>
<b>ТШЗ 21.1</b>	<p>Санал болгож буй барааны нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээний талаарх мэдээлэл ирүүлэх эсэх: <b>“Тийм”</b></p> <p>Чанарын баталгаат хугацаа: <b>3 сар</b></p> <p>Тоног төхөөрөмжийн угсралт, сууринуулалт, туршилт тохируулгатай холбоотой зааварчилгаа, мэдээлэл ирүүлэх эсэх: <b>“Тийм”</b></p> <p>Нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээтэй холбоотой бусад шаардлага: <b>“Үгүй”</b></p>
<b>ТШЗ 22.2</b>	Оролцогчийн санал болгосон тендерийн үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: <b>“Тохируулахгүй”</b>
<b>ТШЗ 22.3</b>	<p>Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэх эсэх: <b>“Тийм”</b></p> <p>Улаанбаатар хот Баянгол дүүргийн 20 дугаар хороо Үйлдвэрийн баруун бүс-1 ХД байрлах “Зорчигч тээвэр тав” ОНӨААТҮГ-ын 1 дүгээр баазын агуулахад өөрийн тээврийн хэрэгслээр ажлын цагаар тээвэрлэн хүргэх.</p>
<b>Г.ТЕНДЕР ИЛГЭЭХ</b>	
<b>ТШЗ 25.4</b>	<p>Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <p>Тендерт оролцогч нь Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь файл үүсгэн ирүүлнэ.</p> <p>Тус файлын эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн эрх бүхий этгээд баталгаажуулан ирүүлнэ.</p> <p>Тендерт оролцогч хуульд заасан үндэслэлээр нууцалж буй баримт бичиг, мэдээлэл бүрд хамаарах хууль зүйн үндэслэлийг тодорхой тайлбарласан тайлбарыг V бүлгийн Маягт 6-ийн дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.</p> <p>Бүх материалыг нууцалж ирүүлсэн тохиолдолд татгалзах үндэслэл болно.</p>
<b>ТШЗ 26.1</b>	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь</p> <p>Огноо: <b>2024 оны 10 дугаар сарын 08-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>09:00 цаг</b></p>



### III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

- Нийлүүлэх бараа нь батлагдсан төсөвт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн, сүүлийн үеийн технологи байвал давуу тал болно.
- Нийлүүлэх цэвэрлэгээний материал нь шинэ, ашиглагдаагүй байна.
- Нийлүүлэх бараа материал, шинж чанар нь энэ техникийн тодорхойлолтод заасантай дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө.
  - Нийлүүлэх бараа нь холбогдох стандартын шаардлагад нийцэж байх шаардлагатай бөгөөд нотлох баримтыг тендерт хавсарган ирүүлнэ. Санал болгож буй барааны фото зураг, тайлбарыг хавсарган ирүүлнэ.

#### Техникийн тодорхойлолт

Санал болгох бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт зохих стандартад нийцсэн байна. Хуулийн 26.8-д зааснаар “эсхүл түүнтэй дүйцэх, ... -тай дүйцэхүйц байна” гэсэн тодотгол хэрэглэсэн техникийн тодорхойлолтод өөр бараа санал болгосон оролцогч техникийн тодорхойлолтод заасантай дүйцэх болохыг ТШЗ 20.2-т заасан баримт бичгээр нотолсон бол техникийн тодорхойлолтыг хангасан гэж үзнэ.

Техникийн тодорхойлолтыг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим хуудасны Урилга -ТЭЗҮ хэсгээс харна уу.

#### Барааны нэр: Цэвэрлэгээний материал

№	Захиалагчийн техникийн тодорхойлолт  (Тухайн барааны үзүүлэлт тус бүрийг дор жагсааж бичих ба хэрээз чанарын баталгаамт хугацаа шаардах бол бичнэ үү.)	Санал болгож буй техникийн тодорхойлолт  (Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)	Тайлбар  (дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)
1			
2			
3			
...			

## ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ МАТЕРИАЛЫН ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2024.10.02

Улаанбаатар хот

№	Материалын нэр төрөл	Техникийн тодорхойлолт
1	Шал угаагч шингэн	<p><b>Усмалын өнгө:</b> Тод ногоон өнгөтэй.</p> <p><b>Найрлага:</b> Ионы бус, анионы халдвартгүйжүүлэгч, бактерийн ба мөөгөнцрийн эсрэг найрлагатай , нэмэлт өнгө болон үнэр оруулагчгүй</p> <p><b>Онцлог чанар:</b> Усаар давтан арчих шаардлагагүй, холимог үйлчилгээтэй цэвэрлэгч, бүх төрлийн хатуу гадаргуу цэвэрлэхэд тохиromжтой, тааламжтай үнэртэй.</p> <p><b>Савлагaa:</b> 1 болон 5л -ээр зориулалтын тунлагч бүхий хэмжээстэй савтай байх.</p> <p>/Детерж аниос бодистой дүйцэхүйц/</p>
2	Мөөгөнцрийн эсрэг, халдвартгүйжүүлэх, ариутгах, цэвэрлэх бодис /шингэн/	<p><b>Усмалын өнгө:</b> Бүтээгдэхүүний нэр төрлөөс хамаарч янз бүр байж болно /өнгөгүй тунгалаг, цагаан, ягаан гэх мэт/</p> <p><b>Найрлага:</b> натрийн перкарбонатад сууринсан нунтаг,</p> <p>К алкил К бензил К, ус төрөгчийн хэт исэл агуулсан, ба мөөгөнцрийн эсрэг найрлагатай, нэмэлт өнгө болон үнэр оруулагчгүй</p> <p><b>Онцлог чанар:</b> Цэвэрлэх болон халдвартгүйжүүлэх хос үйлчилгээтэй, шингэн.</p> <p><b>Зориулалт:</b> Засварын цехийн тостой шал угаах, ариун цэврийн суултуур, ариун цэврийн өрөө, бусад.</p> <p><b>Савлагaa:</b> 500мл зориулалтын тунлагчтай байх./Commet-тэй дүйцэхүйц/</p>
3	Толбо арилгагч 500 мл	<p>МУ-ийн стандартад нийцсэн ба түүнээс дээш, гүн /тос/ толбо сайн арилгадаг байх, хүнд ямар нэг харшил өгөхгүй хадгалах горим алдагдаагүй байх шаардлагатай.</p> <p><b>Савлагaa:</b> 500 мл /CLAX Magic Protein 70B2 бодистой дүйцэхүйц/</p>
4	Эмчийн өрөөний шал, хана, ариун цэврийн өрөө, угаалтуур, тоног төхөөрөмж, гэх мэт гадаргуу халдвартгүйтгэх уусмал	<p><b>Усмалын өнгө:</b> Тод ногоон өнгөтэй.</p> <p><b>Найрлага:</b> N (3 аминодродил)-N додецилпропан-1,3- диамин, N,N-дидецил-N, N-диметиламмоний хлорид, ионжоогүй байгалийн түүхий эд, хелат бүтэц, pH тохируулагч, аромат өнгө оруулагч бодис, ус.</p> <p><b>Онцлог чанар:</b> Альдегид, фенол, идэвхит хлор, фосфат агуулаагүй, эмнэлгийн дотоод халдвартгүйжүүлэгч төрөлд маш мэдрэг нөлөөтэй. Цэвэрлэгээний үед өвчтөнд гаж нөлөө үүсгэхгүй, политир материал,шил резин,гэх мэт гадаргууд хэрэглэхэд тохиromжтой. Уусах чадвар сайтай, хир бохирдлыг сайн арилгадаг. Ажлын уусмал 7 хоногийн турш үйлчилгээгээ алдахгүй хадгалагддаг, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаль орчинд хоргүй байх.</p> <p><b>Савлагaa:</b> 1л /Зориулалтын тунлагч бүхий хэмжээстэй савтай байх.</p> <p>/Сурфаниос премиум бодистой дүйцэхүйц/</p>

		<b>Найрлага:</b> Изотиазолин, парабензоат, феноокси этанол агуулаагүй <b>Савлагаа:</b> 0.5л савлагаатай <b>Тусгай шаардлага:</b> Өнгө үнэр оруулагч агуулаагүй <ul style="list-style-type: none"><li>• Гар хуурайшуулж цочроохос хамгаалсан найрлагатай</li><li>• Харшил төрүүлэгч агуулаагүй</li><li>• Бактер, мөөгөнцрийг устгана</li><li>• Хүүхэд угааж болно</li></ul> /Аниосейф савантай дүйцэхүйц/
6	Гарын хатуу саван	<b>Найрлага:</b> Изотиазолин, парабензоат, феноокси этанол агуулаагүй <b>Савлагаа:</b> Шахмал хатуу, ширхэгээр цаасан савлагаатай <b>Тусгай шаардлага:</b> Өнгө үнэр оруулагч агуулаагүй <ul style="list-style-type: none"><li>• Гар хуурайшуулж цочроохос хамгаалсан найрлагатай</li><li>• Харшил төрүүлэгч агуулаагүй</li><li>• Бактер, мөөгөнцрийг устгана</li><li>• Хүүхэд угааж болно</li></ul> /Аниосейф, safeguard савантай дүйцэхүйц/
7	Ширхэгтэй гарын саван	<b>Найрлага:</b> Изотиазолин, парабензоат, феноокси этанол агуулаагүй <b>Савлагаа:</b> Шахмал хатуу, ширхэгээр цаасан савлагаатай <b>Тусгай шаардлага:</b> Өнгө үнэр оруулагч агуулаагүй <ul style="list-style-type: none"><li>• Гар хуурайшуулж цочроохос хамгаалсан найрлагатай</li><li>• Харшил төрүүлэгч агуулаагүй</li><li>• Бактер, мөөгөнцрийг устгана</li><li>• Гарын арьсны ширхэгт орсон тос арилгах боломжтой</li></ul> /Тод үйлдвэрийн ширхэгтэй гарын савантай дүйцэхүйц/
8	Барааны саван	<b>Найрлага:</b> Изотиазолин, парабензоат, феноокси этанол агуулаагүй <b>Савлагаа:</b> Шахмал хатуу, ширхэгээр цаасан савлагаатай <b>Тусгай шаардлага:</b> Өнгө үнэр оруулагч агуулаагүй <ul style="list-style-type: none"><li>• Гар хуурайшуулж цочроохос хамгаалсан найрлагатай</li><li>• Харшил төрүүлэгч агуулаагүй</li><li>• Бактер, мөөгөнцрийг устгана</li><li>• Хир буртаг арилгана</li></ul> /ТОП үйлдвэрийн савантай дүйцэхүйц/
9	Жавелион Аниос таб	<b>Өнгө:</b> Цагаан өнгөтэй <b>Хэлбэр:</b> Шахмал <b>Найрлага:</b> Натрийн дихлоризоцианурат <b>Онцлог чанар:</b> Цэвэрлэх болон халдвартгүйжүүлэх, pH 6,5, халдвартгүйтгэх идэвхи өндөр байх <b>Савлагаа:</b> №200 ширхэгтэй /МедиТаб бодистой дүйцэхүйц/

		<b>Найрлага:</b> Анионы болон ионы бус гадаргуугийн идэвхт бодис, эфирын тос, 5%-15% нь цеолит, сульфат давс, кальцийн давс, тогтвржулагч
10	Даавуун эдлэл халдвартгүйтгэх нунтаг вок	<b>Микробиологийн хүрээ:</b> бактери устгана.  <b>Онцлох шинж:</b> Бүх төрлийн даавуун эдлэлийг халдвартгүйтгэх, фосфат агуулаагүй, байгальд ээлтэй, бүх температурт угааж болох, толбо арилгаж цайруулах үйлчилгээтэй байх  <b>Савлагaa:</b> 5кг-р савлагдсан. /Фаго лаундри угаалгын нунтагтай дүйцэхүйц/
11	Шингэн нунтаг угаалгын	<b>Найрлага:</b> Хир, бохирдлыг арилгах угаалгын хүчтэй энзимууд  <b>Микробиологийн хүрээ:</b> бактери устгана.  <b>Онцлох шинж:</b> Бүх төрлийн даавуун эдлэлийг халдвартгүйтгэх, фосфат агуулаагүй, байгальд ээлтэй, бүх температурт угааж болох, толбо арилгаж цайруулах үйлчилгээтэй байх  <b>Савлагaa:</b> 5л-ээр савлагдсан байх /Green ultra wash угаалгын нунтагтай дүйцэхүйц/
12	Угаалгын шингэн бодис	<b>Найрлага:</b> Хир, бохирдлыг арилгах угаалгын хүчтэй энзимууд  <b>Микробиологийн хүрээ:</b> бактери устгана.  <b>Онцлох шинж:</b> Бүх төрлийн шил, толь, пластик, төмөр эдлэлийг халдвартгүйтгэх, фосфат агуулаагүй, байгальд ээлтэй, бүх температурт угааж болох, толбо арилгаж цэвэрлэх үйлчилгээтэй байх.  <b>Савлагaa:</b> 20л-ээр савлагдсан байх бөгөөд зориулалтын жижиг савыг 50 ширхгийг дагалдуулан авна. /Тод угаалгын шингэнтэй дүйцэхүйц/
13	Шил арчигч шингэн	<b>Найрлага:</b> Хир, бохирдлыг арилгах угаалгын хүчтэй энзимууд  <b>Микробиологийн хүрээ:</b> бактери устгана.  <b>Онцлох шинж:</b> Төв оффиссын гадна, дотор шилэн фасад, шилэн хаалтыг халдвартгүйтгэх, фосфат агуулаагүй, байгальд ээлтэй, бүх температурт угааж болох, толбо арилгаж цэвэрлэх үйлчилгээтэй байх. Усаар давтан арчих шаардлагагүй, хатуу гадаргуу цэвэрлэхэд тохиромжтой, тааламжтай үнэртэй.  <b>Савлагaa:</b> 20л-ээр савлагдсан байх бөгөөд зориулалтын жижиг савыг 50 ширхгийг дагалдуулан авна. /Тод угаалгын шингэнтэй дүйцэхүйц/
14	Плита угаагч шингэн	<b>Найрлага:</b> Хир, бохирдлыг арилгах угаалгын хүчтэй энзимууд  <b>Микробиологийн хүрээ:</b> бактери устгана.  <b>Онцлох шинж:</b> Төв оффисын дотор шалны плитаг халдвартгүйтгэх, фосфат агуулаагүй, байгальд ээлтэй, бүх температурт угааж болох, толбо арилгаж цэвэрлэх үйлчилгээтэй байх. Плитаны зориулалтын шингэн цэвэрлэгч бодис байна. Усаар давтан арчих шаардлагагүй, хатуу гадаргуу цэвэрлэхэд тохиромжтай, тааламжтай үнэртэй.  <b>Савлагaa:</b> 1л-ээр савлагдсан байх /Tio угаалгын шингэнтэй дүйцэхүйц/
15	Пракет угаагч шингэн	<b>Найрлага:</b> Хир, бохирдлыг арилгах угаалгын хүчтэй энзимууд  <b>Микробиологийн хүрээ:</b> бактери устгана.

		<p><b>Онцлох шинж:</b> Төв оффиссын дотор пракетн шалыг халдвартгүйтгэх, фосфат агуулаагүй, байгальд ээлтэй, бүх температурт угааж болох, толбо арилгаж цэвэрлэх үйлчилгээтэй байх. Паркетны зориулалтын шингэн цэврлэгч бодис байна. Усаар давтан арчих шаардлагагүй, хатуу гадаргуу цэвэрлэхэд тохиромжтай, тааламжтай үнэртэй.</p> <p><b>Савлагаа:</b> 1л-ээр савлагдсан байх</p>
16	Уут /том/	<p><b>Хэмжээ:</b> 70см *80 см /40литр/ 1 боодолд 100 ширхэгтэй.</p> <p><b>Зориулалт:</b> Ахуйн хог хаягдал хийх,</p> <p><b>Утанд тавигдах шаардлага:</b></p> <p>Амархан цоорч гэмтэхгүй, шингэн нэвчихгүй, хлор агуулаагүй нийлэг материалыаар хийгдсэн</p> <p>7 микронос багагүй зузаантай ISO 7765:2004 шаардлагад нийцсэн байх</p>
17	Уут /жижиг/	<p><b>Хэмжээ:</b> 50см *30 см 1 боодолд 100 ширхэгтэй.</p> <p><b>Зориулалт:</b> Ахуйн хог хаягдал хийх,</p> <p><b>Утанд тавигдах шаардлага:</b></p> <p>Амархан цоорч гэмтэхгүй, шингэн нэвчихгүй, хлор агуулаагүй нийлэг материалыаар хийгдсэн</p> <p>7 микронос багагүй зузаантай ISO 7765:2004 шаардлагад нийцсэн байх</p>
18	Үнэртүүлэгч	<p><b>Найрлага:</b> Агаарын эвгүй үнэр дарах бодисууд</p> <p><b>Зориулалт:</b> Ариун цэврийн өрөөнд хэрэглэнэ,</p> <p><b>Тавигдах шаардлага:</b> Хүний биед харшил өгөхгүй, тааламжтай үнэртэй, үнэрээ удаан барьдаг, Сайн чанарын Олон улсын стандартын шаардлага хангасан байх.</p> <p><b>Савлагаа:</b> Суурилуулдаг шингэн эсвэл шүршдэг шингээр савлагдсан байх</p>
19	Гар, нүүрийн алчуур	<p><b>Найрлага:</b> Цэвэр даавуун</p> <p><b>Зориулалт:</b> Шал, тоос шороо арчих</p> <p><b>Тавигдах шаардлага:</b> Сайн чанарын Олон улсын стандартын шаардлага хангасан байх.</p>
20	Илгэн алчуур	<p><b>Найрлага:</b> Илгэн алчуур</p> <p><b>Хэмжээ:</b> 30см *40 см</p> <p><b>Зориулалт:</b> Шил, цонх арчих</p> <p><b>Тавигдах шаардлага:</b> Сайн чанарын Олон улсын стандартын шаардлага хангасан байх.</p>
21	Шалавч /том/	<p><b>Хэмжээ:</b> 100см *70 см</p> <p><b>Зориулалт:</b> Оффист хаалгануудын үүдэнд тавин гутлын шороо тоос, цас, шавар арчих.</p> <p><b>Тавигдах шаардлага:</b> Сайн чанарын Олон улсын стандартын шаардлага хангасан байх.</p>
22	Шалавч /жижиг/	<p><b>Хэмжээ:</b> 70см *40 см</p> <p><b>Зориулалт:</b> Оффист хаалгануудын үүдэнд тавин гутлын шороо тоос, цас, шавар арчих.</p> <p><b>Тавигдах шаардлага:</b> Сайн чанарын Олон улсын стандартын шаардлага хангасан байх.</p>
23	Хогийн сав /том/	<p><b>Хэмжээ:</b> 70-100л багтаамжтай</p> <p><b>Зориулалт:</b> Гадна талбайд тавих.</p> <p><b>Тавигдах шаардлага:</b> Сайн чанарын Олон улсын стандартын шаардлага хангасан байх. Байгаль орчинд ээлтэй, сүүлийн үеийн технологиор үйлдвэрлэгдсэн, тагтай байх.</p>

24	Хогийн сав /дунд/	<b>Хэмжээ:</b> 20-30л багтаамжтай <b>Зориулалт:</b> Оффисын өрөөнд тавих. <b>Тавигдах шаардлага:</b> Сайн чанарын Олон улсын стандартын шаардлага хангасан байх. Байгаль орчинд ээлтэй, сүүлийн үеийн технологиор үйлдвэрлэгдсэн, тагтай байх.
25	Хогийн сав /жижиг/	<b>Хэмжээ:</b> 10л багтаамжтай <b>Зориулалт:</b> Оффисын өрөөнд тавих. <b>Тавигдах шаардлага:</b> Сайн чанарын Олон улсын стандартын шаардлага хангасан байх. Байгаль орчинд ээлтэй, сүүлийн үеийн технологиор үйлдвэрлэгдсэн, гишгэж онгойдог тагтай байх.
26	Шалны модтой шал угаах хувин	<b>Хэмжээ:</b> 10-20л багтаамжтай <b>Зориулалт:</b> Оффисын өрөө тасалгааны шал арчих, цэвэрлэх.  <b>Тавигдах шаардлага:</b> Сайн чанарын Олон улсын стандартын шаардлага хангасан байх. Өөрөө мушгих зориулалттай, мушгидаа дуу чимээ гаргадаггүй байх. Шалны модны алчуур нь тоос шороо, хэр буртаг сайн авдаг, ус шингээх чадвар сайтай материалаар хийгдсэн байх.  <b>Тусгай шаардлага: 1 ком хувинг дагалдаж 10ш шалны зориулалтын модны алчуур дагалдуулж авна.</b>
27	Хувин	<b>Хэмжээ:</b> 3-5л багтаамжтай <b>Зориулалт:</b> Ус зөөх <b>Тавигдах шаардлага:</b> Сайн чанарын Олон улсын стандартын шаардлага хангасан байх. Хуванцар материалаар хийгдсэн байх.
28	Дамартай ариун цэврийн цаас	<b>Хэмжээ:</b> 300метрийн урттай, 24 см-ийн өргөнтэй байх. <b>Зориулалт:</b> Ариун цэврийн өрөөнд тавих. <b>Тавигдах шаардлага:</b> Сайн чанарын Олон улсын стандартын шаардлага хангасан байх.  Бүх насны хүн хэрэглэхэд тохиромжтой, үнэргүй, цагаан өнгөтэй, цаас бургидаггүй, зузаан, дамартай байх. /Өд-тэй дүйцэхүйц байх/
29	Дамартай ариун цэврийн цаас тогтоогч	<b>Хэмжээ:</b> 300метрийн урттай, 24 см-ийн өргөнтэй дамартай ариун цэврийн цаас хийхэд таарч байх. <b>Зориулалт:</b> Ариун цэврийн цаас хийх <b>Тавигдах шаардлага:</b> Сайн чанарын Олон улсын стандартын шаардлага хангасан байх.
30	Бээлий /резин/	<b>Хэмжээ:</b> 30-аас дээш см-ийн урттай байх. <b>Зориулалт:</b> Цэвэрлэгээ, ариутгалд <b>Тавигдах шаардлага:</b> Сайн чанарын Олон улсын стандартын шаардлага хангасан байх. Халуун, хүйтэн усанд дүрж хэрэглэхэд тохиромжтой, үнэргүй, зузаан резинэн материалтай байх.
31	Бээлий /ажлын/	<b>Зориулалт:</b> Албан хэрэгцээнд  <b>Тавигдах шаардлага:</b> Сайн чанарын Олон улсын стандартын шаардлага хангасан байх. Резинэн алгатай, сайн чанарын нэхмэл материалтай байх.
32	Тармуур	<b>Зориулалт:</b> Албан хэрэгцээнд гадна талбайн хог цэвэрлэх  <b>Тавигдах шаардлага:</b> Сайн чанарын Олон улсын стандартын шаардлага хангасан байх. 150см-ийн урт иштэй төмөр материалтай байх.

33	Хүрз	<b>Зориулалт:</b> Албан хэрэгцээнд гадна талбайн хог цэвэрлэх  <b>Тавигдах шаардлага:</b> Сайн чанарын Олон улсын стандартын шаардлага хангасан байх. 150см-ийн урт иштэй төмөр материалтай байх.
34	Дэрсэн шүүр	<b>Зориулалт:</b> Албан хэрэгцээнд зам, талбайн хог цэвэрлэх  <b>Тавигдах шаардлага:</b> Гар аргаар үйлдвэрлэсэн, дэрс нь 100см-аас багагүй урт дэрстэй, модон иштэй байх.
35	Хогийн шүүр, тосгуур	<b>Зориулалт:</b> Албан хэрэгцээнд өрөө, тасалгааны хог цэвэрлэх  <b>Тавигдах шаардлага:</b> Сайн чанарын Олон улсын стандартын шаардлага хангасан байх. Хог сайн авдаг 120 см-аас багагүй урт иштэй, эдэлгээ даах сайн чанарын материалаар хийсэн байх.
36	Хогны түрдэг тэргэнцэр/	<b>Зориулалт:</b> Албан хэрэгцээнд граж болон засварын хог хаях,  <b>Тавигдах шаардлага:</b> Сайн чанарын Олон улсын стандартын шаардлага хангасан байх. 4 улиралд ашиглах, 2 дугуйтай, төмөр рамтай, өөр дээрээ лист төмөр нь дээр хогны савтай байх.
37	Амны хаалт	<b>Зориулалт:</b> Албан хэрэгцээнд засварын ажилчид болон өвчтэй хүн тусгаарлах,  <b>Тавигдах шаардлага:</b> Сайн чанарын 3-н давхар шүүлтүүртэй, Олон улсын стандартын шаардлага хангасан байх.

---oOo---

## БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

№	Барааны нэр	Тоо хэмжээ /1сарын хэрэгцээ/	Хэмж их нэгж, тун	Барааг хүргэх эцсийн цэг	Бараа нийлүүлэх хугацаа	
					Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа)	Нийлүүлэгчийн санал болгох хугацаа (Оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7
1.	Шал угаагч шингэн	125 литр		Улаанбаатар хот, БГД-ийн 20 дугаар хороо Үйлдвэрийн баруун бүс-1 ХД байрлах “Зорчигч тээвэр тав” ОНӨААТҮГ-ын 1 дүгээр баазын агуулахад хүргэнэ.	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 7 хоногт багтаан авна.	
2.	Мөөгөнцрийн эсрэг, халдвартгүйжүүлэх, ариутгах, цэвэрлэх бодис /шингэн/	200 ширхэг				
3.	Толбо арилгагч 500 мл	60 ширхэг				
4.	Эмчийн өрөөний шал, хана, ариун цэврийн өрөө, угаалтуур, тоног төхөөрөмж, гэх мэт гадаргуу халдвартгүйтгэх уусмал	25 литр				
5.	Гарын шингэн саван	30 литр				
6.	Гарын хатуу саван	125 ширхэг				
7.	Ширхэгтэй гарын саван	125 ширхэг				

8.	Барааны саван	250 ширхэг			
9.	Жавелион Аниос таб	100 хайрцаг			
10.	Даавуун эдлэл халдвартгүйтгэх нунтаг вок	125 кг			
11.	Шингэн угаалгын нунтаг	125 литр			
12.	Угаалгын шингэн бодис	520 литр			
13.	Шил арчигч шингэн	125 литр			
14.	Плита угаагч шингэн	15 литр			
15.	Пракет угаагч шингэн	25 литр			
16.	Уут /том/	250 боодол			
17.	Уут /жижиг/	250 боодол			
18.	Үнэртуулэгч	100 ширхэг			
19.	Гар, нүүрийн алчуур	600 ширхэг			

20.	Илгэн алчуур	500 ширхэг			
21.	Шалавч /том/	15 ширхэг			
22.	Шалавч /жижиг/	20 ширхэг			
23.	Хогийн сав /том/	15 ширхэг			
24.	Хогийн сав /дунд/	20 ширхэг			
25.	Хогийн сав /жижиг/	30 ширхэг			
26.	Шалны модтой шал угаах хувин	15 ком			
27.	Хувин	20 ширхэг			
28.	Дамартай ариун цэврийн цаас	100 ширхэг			
29.	Дамартай ариун цэврийн цаас тогтоогч	16 ширхэг			
30.	Бээлий /резин/	350 ширхэг			
31.	Бээлий /ажлын/	5000 ширхэг			

32.	Тармуур	10 ширхэг			
33.	Хүрз	12 ширхэг			
34.	Дэрсэн шүүр	15 ширхэг			
35.	Хогийн шүүр, тосгуур	15 ширхэг			
36.	Хогны түрдэг тэргэнцэр	6 ширхэг			
37.	Амны хаалт /Хайрцагтаа 50ш/	250 хайрцаг			

----оо----

#### **IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ**

Захиалагч энэ бүлэгт оролцогчийн бөглөх шаардлагатай бүх маягтыг тусгана.

**Маягтын жагсаалт:**

<b>Маягт 1: Тендер илгээх маягт .....</b>	<b>26</b>
<b>Маягт 2: Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл.....</b>	<b>27</b>
<b>Маягт 3: Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл .....</b>	<b>27</b>
<b>Маягт 4: Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл .....</b>	<b>27</b>
<b>Маягт 5: Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт .....</b>	<b>27</b>

## Маягт 1: Тендер илгээх маягт

[огноо]

### [Захиалагч байгууллагын нэр]

Манай [оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [тендер шалгаруулалтын нэр, дугаар] тендер шалгаруулалтын үнийн санал дуудах ажиллагаанд эцсийн санал болгосон үнээр тендерийн баримт бичигт заасан хуваарийн дагуу бараа нийлүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендерийн баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцох холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаarahгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна:
  - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
  - 2.1. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
  - 3.1. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй.
  - 4.1. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаarahгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш [30 ба түүнээс дээш хоногийн тоо] хоногийн хугацаанд хүчинтэй байна<sup>1</sup>
5. Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 6 дугаар зүйл, 13.4 болон 17.1-д заасныг зөрчсөн, эсхүл тендерт хуурамч баримт бичиг, мэдээллийг хүргүүлсэн бол уг тендерийг илт худал мэдээлэл бүхий тендер гэж тооцохыг хүлээн зөвшөөрч байна.
6. Тендерт санал болгосон бараа нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын догодолгүй болохыг баталж байна.
7. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

**Баталгаажуулсан: Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд, эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр, албан тушаал, гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг]:**

**Хаяг мэдээлэл:**

**Маягт 2: Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл**

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

**Маягт 3: Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл**

Оролцгчийн нэр: [түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

**Маягт 4: Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл**

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

**Маягт 5: Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт**

	Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Нууцалсан хууль зүйн үндэслэл
1.		
2.		
3.		
4.		
5.		

## V БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

### Санамж

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж бараа худалдан авахад энэхүү гэрээний нөхцөлийг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), түүнд заасан бусад баримт бичиг нь захиалагч, гүйцэтгэгч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно.

Энэ гэрээ нь захиалагчаас бараа, түүнтэй холбогдох бараа худалдан авах харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах бол ГТН-ийн холбогдох заалтад тухайн бараа худалдан авах нөхцөлд тохируулан өөрчлөлт оруулан ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

1. ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн бараа худалдан авахад хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;
2. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
3. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
4. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
5. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөхгүй байх;
6. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохиорох үг өгүүлбэр, too хэмжээ зэрэгт нийцүүлэн тусгана. ГТН-д заасан зарим жишээ, нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.

## ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

### НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

#### Тодорхойлолт

- 1.1. Гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл нь дор дурдсан утгыг агуулна:
  - 1.1.1. “Бараа” гэж Нийлүүлэгчээс Захиалагчид нийлүүлэхээр Тендерт ирүүлсэн хөрөнгийг;
  - 1.1.2. “Дагалдах үйлчилгээ” гэж бараа нийлүүлэхтэй холбоотой угсралт, суурилуулалт, сургалт, засвар үйлчилгээ болон Нийлүүлэгчийн үзүүлэх бусад үйлчилгээг;
  - 1.1.3. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
  - 1.1.4. “Нийлүүлэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
  - 1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Нийлүүлэгчийг хамтад нэрлэснийг;
  - 1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
  - 1.1.7. “Бараа нийлүүлэх нөхцөл” гэж Захиалагчийн техникийн тодорхойлоптод нийцүүлж Тендерт тусгасан бараа бэлтгэх, нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг ойлгоно. Тендерт тусгайлан заагаагүй бараа нийлүүлэх нөхцөлийг Техникийн тодорхойлоптод тусгаснаар ойлгоно. Хуулийн 30.2, 34.2-т зааснаар хэлэлцээ хийсэн тохиролцоо нь Гэрээнд тусгагдсан бол Бараа нийлүүлэх нөхцөлийн нэг хэсэг болно.
  - 1.1.8. “Бараа нийлүүлэх газар” гэж барааг хүлээлгэн өгөх болон дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг;
  - 1.1.9. “Доголдол” гэж нийлүүлсэн бараа, дагалдах үйлчилгээний барааны шинж байдал, чанар тоо хэмжээ нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерээс зөрүүтэй байхыг;
  - 1.1.10. “Баталгаат хугацаа” гэж нийлүүлсэн барааг зориулалтын дагуу ердийн байдлаар ашиглах явцад бараанд илэрсэн доголдлыг нийлүүлэгч хариуцах хугацааг;
  - 1.1.11. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж гэрээгээр баталгаат хугацаа тогтоогоогүй бол Захиалагчаас доголдолтой холбогдуулж Нийлүүлэгчид шаардлага гаргах хугацааг;
  - 1.1.12. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Нийлүүлэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;
  - 1.1.13. “Нийлүүлэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Нийлүүлэгчээс томилогдсон этгээдийг;
  - 1.1.14. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны

<p><b>Гэрээний тайлбар</b></p> <p><b>Бараа нийлүүлэх</b></p> <p><b>Бараа нийлүүлэх газар</b></p> <p><b>Бараа нийлүүлэх хугацаа, түүнийг сунгах</b></p> <p><b>Барааг хүлээлгэн өгөх</b></p>	<p>үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориотой өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.</p> <p>1.2.Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:</p> <ul style="list-style-type: none"> <li>1.2.1.Ганц тоог илэрхийлсэн үг нь олон тоог, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоог хамааруулж болно.</li> <li>1.2.2.Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.</li> <li>1.2.3.Зүйл, заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томьёог үндэслэн тайлбарлахад бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад үндэслэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.</li> <li>1.2.4.Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.</li> <li>1.2.5.Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.</li> </ul> <p style="text-align: center;"><b>ХОЁР НИЙЛҮҮЛЭГЧ</b></p> <p>2.1.Нийлүүлэгч нь гэрээнд заасан бараа нийлүүлэх нөхцөл, нийлүүлэлтийн хуваарь, ГТН-д заасан хугацааг баримтлан Бараа нийлүүлэх, Дагалдах үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй</p> <p>2.2.Нийлүүлэгч гэрээний дагуу Дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай ажилтан, тоног төхөөрөмж зэргийг Төндерт санал болгосноор оролцуулах ба гүйцэтгэлийн явцад эдгээрт өөрчлөлт орох зайлшгүй шаардлагатай нөхцөл үүссэн бол Захиалагчаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авна</p> <p>2.3.ГЕН-ийн 2.2-т заасны дагуу өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн шаардсан техникийн чадавх, туршлагын шаардлагыг хангасан байна.</p> <p>2.4.Нийлүүлэгч нь Барааг нийлүүлэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, бусад зүйлийг гаргуулахыг хүссэн тохиолдолд Захиалагч ердийн боломжит хугацаанд гаргаж өгнө.</p> <p>2.5.Бараа нийлүүлэх болон Дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг ГТН-д заана.</p> <p>2.6.Бараа нийлүүлэх хугацааг нийлүүлэлтийн хуваарийг үндэслэн ГТН-д заана.</p> <p>2.7.Нийлүүлэгч дараах нөхцөл бий болсон тохиолдолд бараа нийлүүлэлтийн хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:</p> <ul style="list-style-type: none"> <li>2.7.1.Захиалагч ГЕН-ийн 2.4-д заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;</li> <li>2.7.2.Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон.</li> </ul> <p>2.8.Захиалагч ГЕН-ийн 2.7-д заасан нөхцөлийн аль нэг нь бүрдсэн гэж үзвэл Нийлүүлэлгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.</p> <p>2.9.ГЕН-ийн 2.7.2-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Нийлүүлэгч нотлох үүрэгтэй.</p> <p>2.10.Нийлүүлэгч нь Барааг ГТН-д заасан нөхцөлөөр хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг бүрэн үзүүлж, баримт (хүлээлцэн акт) үйлдэнэ.</p>
--	--

<b>Барааны гарал үүслийн улс</b>	2.11.Нийлүүлэгч нь барааг хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг үзүүлснээр Захиалагчид барааны өмчлөх эрх шилжинэ. 2.12.Гэрээний дагуу нийлүүлэх Бараа нь Тендерт заасан улсын гарал үүсэлтэй байна. 2.13.Нийлүүлэгчийн Тендерийг шалгаруулахад түүнд давуу эрх олгосон бол үнэлгээний явцад үнийг нь хийсвэрээр бууруулж тооцсон аливаа бараа нь заавал Монгол Улсын гарал үүсэлтэй бараа байна.
<b>Баглаа боодол</b>	2.14.Нийлүүлэгч барааг ГЕН-ийн 2.5-д заасан газар хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудах, дутах зэрэг доголдлоос урьдчилан сэргийлэх сав, баглаа боодлыг ГТН-д заасны дагуу хийнэ. 2.15.Сав, баглаа боодол, түүний хаягдал нь хүрээлэн буй орчинд учруулах сөрөг нөлөөллийг хамгийн бага байхаар сонгоно. Сав, баглаа боодолд хууль тогтоомжоор хориглосон материал ашиглахыг хориглоно. 2.16.Нийлүүлэгч баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ ГТН-д заасан шаардлага болон Захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг мөрдөнө. 2.17.Гэрээнд Худалдааны нөхцөл (Incoterms)-ийг хэрэглэх бол тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ-ны 20.6-д заасан нөхцөлийг ГТН-д тусгана. 2.18.ГТН-д заагаагүй бол Incoterms 2020 Delivery Duty Paid /DDP/ нөхцөлөөр бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.
<b>Худалдааны нөхцөл</b>	<b>ГУРАВ. ЗАХИАЛАГЧ</b>
<b>Барааг хүлээн авах</b>	3.1.Захиалагч нь барааг хүлээн авч, хүлээлцсэн баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ. 3.2.Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл явц Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт нийцэж буй эсэхийг хянах зорилгоор Захиалагч шалгалт, туршилт явуулах эрхтэй. Шалгалт, туршилт хийх хугацаа, журмын талаар Захиалагч нь Нийлүүлэгчид бичгээр урьдчилан мэдэгдэнэ. 3.3.Шалгалт, туршилтын явцыг тэмдэглэл үйлдэн талууд баталгаажуулах бөгөөд бараа, дагалдах үйлчилгээ доголдолтой тохиолдолд Захиалагч доголдлыг арилгуулахаар Нийлүүлэгчид мэдэгдэл хүргүүлнэ. 3.4.ГЕН-ийн 3.3-т заасан мэдэгдлийн дагуу Нийлүүлэгч барааны доголдлыг арилгах арга хэмжээ авна. 3.5.Барааг хүлээн авахаас өмнө Захиалагч шалгасан, туршсан байх нь хүлээн авах үед түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд барааг хүлээн авахаас татгалзах, доголдолтой холбогдуулж шаардлага гаргах Захиалагчийн эрхийг хязгаарлахгүй. 3.6.Шалгалт, туршилт хийхтэй холбоотой аливаа зардлыг Нийлүүлэгч хариуцна. 3.7.Гэрээний үнийг Гэрээ баталгаажуулах маягтад заана. 3.8.Гэрээний үнэд хуулийн 40.4-д заасан үндэслэлээр тохироулга хийх эсэх, тохироулга хийх бол аргачлалыг ГТН-д заана. 3.9.Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг Нийлүүлэгчид төлнө.
<b>Гэрээний үнэ</b>	
<b>Төлбөр төлөх</b>	

3.10. Нийлүүлэгчийн хүсэлтээр Захиалагч Бараа нийлүүлэх хугацааг ГЕН-ийн 2.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.

3.11. Захиалагч нь гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон бусад холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.

3.12. Захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй.

3.13. ГЕН-ийн 3.8-д заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.

3.14. Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.

3.15. Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Нийлүүлэгчид төлөх төлбөрөөс суутгана.

### **ДӨРӨВ. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА**

<b>Захиалагчийн эрсдэл</b>	<b>Хүлээх</b>	4.1. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна: 4.1.1. Барааг захиалагчид шилжүүлснээс хойш бараа нь ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар гэмтсэн, устсан; 4.1.2. Нийлүүлэгч Барааг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөх тодорхой үйлдэл хийсэн боловч Захиалагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүлээн аваагүй (доголдолтой бараанд хамаарахгүй) байх хугацаанд ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар Бараа гэмтсэн, устсан.
<b>Даатгал</b>		4.2. Нийлүүлэгч нь барааг үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, хүлээлгэн өгөх үед гарч болох эрсдэлээс хамгаалж ГТН-д заасны дагуу даатгуулж, даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг Захиалагчид ирүүлнэ. Даатгалын хураамжийг Нийлүүлэгч хариуцна.
<b>Доголдол</b>		4.3. Захиалагч бараа, дагалдах үйлчилгээг шалгаж, илэрсэн зөрчил, доголдлын талаар Нийлүүлэгчид мэдэгдэнэ. 4.4. Захиалагч зөрчил, доголдлыг илрүүлэх зорилгоор барааны далд хэсгийг нээх, шалгалт, туршилт хийх эрхтэй. 4.5. Захиалагч ГТН-д заасан баталгаат хугацаа эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид өгнө. 4.6. Доголдол арилгах мэдэгдэл өгсөн тухай бүр Нийлүүлэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана. 4.7. Нийлүүлэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгана. 4.8. Захиалагчийн гаргасан зардлыг Нийлүүлэгч Захиалагчид үл маргах журмаар төлнө. 4.9. Захиалагч нь ГЕН-ийн 4.7-д заасан зардлыг Чанарын баталгаанаас суутгаж болох бөгөөд Чанарын баталгаа хүрэлцээгүй тохиолдолд илүү гарсан зардлыг Нийлүүлэгч нь Захиалагчид үл маргах журмаар төлнө.
<b>Чанарын баталгаа</b>		4.10. Бараа, дагалдах үйлчилгээний баталгаат хугацааг ГТН-д заана. 4.11. ГТН-д заасан бол чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно.

		4.12. Нийлүүлэгч Чанарын баталгааг хуулийн 43.7-д заасны дагуу баталгаажуулж болно.
		4.13. ГЕН-ийн 4.12-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.
		4.14. Баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Бараанд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.
		4.15. ГЕН-ийн 4.7-д зааснаар Захиалагч догоилдлыг арилгасан бол догоилдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Нийлүүлэгчид олгоно.
		4.16. ГЕН-ийн 4.7-д заасны дагуу догоилдлыг арилгасан тохиолдолд баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.
Алданги		4.17. Нийлүүлэгч нь барааг хуваарийн дагуу буюу гэрээнд заасан хугацаанд нийлүүлэгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.
Оюуны өмчийн эрх зөрчих		4.18. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Нийлүүлэгчид төлнө.
Гэнэтийн давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал	буюу	4.19. Барааг өмчлөх, эзэмших, ашиглах явцад гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.
Үүрэг гүйцэтгүүлэх нэмэлт хугацаа		4.20. Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Нийлүүлэгч нь энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 6.10-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.
Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах үндэслэл		4.21. Нийлүүлэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.
		4.22. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцэж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.
		4.23. Гэрээг хэрэгжүүлэх Захиалагчийн зааварчилгаа, Нийлүүлэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Нийлүүлэгч ГЕН-ийн 2.7-д заасан хүсэлт гаргаж болно.
		4.24. Гэрээний нэг тал нь үүргийн зөрчил гаргасан тохиолдолд нэгөө талд үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоож, мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.
		4.25. Иргэний хуулийн 226 дугаар зүйлд заасан үндэслэл бий болсон тохиолдолд эсхүл Нийлүүлэгч ГЕН-ийн 2.13-т заасныг зөрчсөн бол нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.
		<b>ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ</b>
		5.1. Захиалагч дараах үндэслэлийн аль нэг нь хангагдсан тохиолдолд гэрээнээс татгалзах эсхүл гэрээг цуцлах эрхтэй:
		5.1.1. Нийлүүлэгч гэрээнд заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас

Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоосон боловч нэмэлт хугацаанд гүйцэтгээгүй;

5.1.2.Бараа нийлүүлэх хугацаанд Нийлүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусч сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон;

5.1.3.Нийлүүлэгч ГЕН-ийн 6.5-д заасан үүргээ зөрчсөн нь тогтоогдсон.

5.1.4.Нийлүүлэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй.

5.2.Нийлүүлэгч тендерт оролцох буюу бараа нийлүүлэх явцдаа авлига, залилан мэхлэх гэмт хэрэг үйлдсэн нь шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон.

5.3.Захиалагч нь төлбөр хийх хугацаа хэтэрсэн тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй тохиолдолд Нийлүүлэгч гэрээг цуцалж болно.

5.4.Нийлүүлэгч ямар ч тохиолдолд гэрээнээс татгалзах эрхийг хэрэгжүүлэхгүй.

5.5.Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэлд гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах болсон үндэслэл, цаашид гэрээг дуусгавар болсонтой холбоотой авах арга хэмжээний тухай тусгасан байна.

### **ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ**

#### **Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэл**

##### **Төлөөлөгч**

6.1.Талууд өөрийн төлөөлөгчийг томилж, томилсон төлөөлөгчийн мэдээллийг гэрээ баталгаажуулах маягтад заана.

6.2.Төлөөлөгчийн мэдээлэлд түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаяг тэмдэглэгдсэн байна.

6.3.Гэрээ хэрэгжүүлэх явцад төлөөлөгч солигдсон бол Төлөөлөгч солигдсон тухай болон түүний мэдээллийг агуулсан мэдэгдлийг нөгөө талд бичгээр хүргүүлнэ.

6.4.Төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

6.5.Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж байгаа тохиолдолд Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт зааснаас илүү хувийг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.

6.6.Туслан гүйцэтгэгчийн аливаа зөрчлийг (хугацаа хэтрүүлэх, ажлын доголдол гэх мэт) Нийлүүлэгч хариуцах бөгөөд Туслан гүйцэтгэгч өөрчлөгдсөн тохиолдолд ГЕН-ийн 2.3-д заасан журмыг баримтална.

6.7.Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бүхий байгууллага шаардсанаас бусдад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.

6.8.Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийг хамт өгнө.

6.9.Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.

##### **Туслан гүйцэтгэгч**

##### **Нууцлал**

##### **Мэдэгдэл**

6.10.Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг ГЕН-ийн 6.9 -д зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.

6.11.Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан Төлөөлөгчийн хаягаар илгээнэ.

6.12.Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:

6.12.1.баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр, төлбөр төлсөн баримтыг үндэслэн;

6.12.2.биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.

6.13.Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

6.14.ГЕН-ийн 6.13-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.

6.15.Дараах тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна:

6.15.1.ГЕН-ийн 2.8-т заасны дагуу хугацаа сунгагдсан;

6.15.2.үнийн тохируулга хийсэн.

6.16.Гэрээний нэмэлт, өөрчлөлтөд талуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

6.17.ГЕН-ийн 6.15-д зааснаас бусад тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй.

6.18.Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

6.19.Талууд зөвшилцөн, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

**Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах**

**Маргаан шийдвэрлэх**

## ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

<b>ГЕН 2.5.</b>	<p>Бараа нийлүүлэх газар: “Зорчигч тээвэр тав” ОНӨААТҮГ Улаанбаатар хот, БГД-ийн 20 дугаар хороо үйлдвэрийн баруун бүс-1 ХД байрлах Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ-ын 1 дүгээр баазын агуулахад өөрийн тээврийн хэрэгслээр ажлын цагаар тээвэрлэн хүргэнэ.</p>
<b>ГЕН 2.6.</b>	Бараа нийлүүлэх хугацаа: Гэрээ байгуулагдсан өдрөөс хойш 7 хоног.
<b>ГЕН 2.10.</b>	<p>Бараа хүлээлгэн өгөх нөхцөл:</p> <p>Нийлүүлэгч барааг гэрээний тусгай нөхцөлд заасан газарт холбогдох албан тушаалтанд үзлэг шалгалт, туршилтыг хийлгэн хүлээлгэн өгч бараа хүлээлцсэн акт үйлдэнэ.</p> <p>Бараанд холбогдох баримт бичиг:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Барааны гарал үүслийн гэрчилгээ,</li> <li>2. Чанарын шаардлага хангаж буйг нотлох баримт, гэрчилгээ,</li> <li>3. Нийлүүлэгдэж буй барааны нэр төрөл, тоо хэмжээ, нэгж болон нийтүнийг заасан зарлагын баримт, нэхэмжлэх, барааны фото зураг.</li> </ol>
<b>ГЕН 2.14.</b>	<p>Баглаа, боодол:</p> <p>Нийлүүлэх бараа нь ашиглагдаагүй, шинэ, хайрцаг савтай байна.</p>
<b>ГЕН 2.17.</b>	<p>Худалдааны нөхцөл:</p> <p>Incoterms 2020 DDP</p>
<b>ГЕН 3.9.</b>	<p>Төлбөр төлөх хугацаа:</p> <p>Гэрээний төлбөрийг гэрээ дүгнэсэн протокол баталгаажсан өдрөөс хойш 90 хоногийн дотор нэхэмжлэхийн дагуу төлнө.</p> <p>Нийлүүлэгчид урьдчилгаа төлбөр олгож болно.</p> <p>Хэрэв нийлүүлэгч нь урьдчилгаа төлбөр авах бол Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу олгоно.</p>
<b>ГЕН 4.10.</b>	<p>Баталгаат хугацаа:</p> <p>Барааны чанарын баталгаат хугацаа 3 сар байна.</p> <p>Чанарын баталгаат хугацаа нь бараа нийлүүлсэн акт баталгаажсан өдрөөс хойш тооцогдоно. Баталгаат хугацаанд ашиглалтын норм хүрэхгүй байх, үйлдвэрлэгчээс шалтгаалан гарах аливаа гологдол асуудлыг нийлүүлэгч 100% бүрэн хариуцна.</p>
<b>ГЕН 4.11</b>	<p>Чанарын баталгаа:</p> <p>Чанарын баталгаа шаардах эсэх: Чанарын баталгаа шаардана.</p> <p>Чанарын баталгааны дүн: Гэрээний нийт үнийн дүнгийн 05 хувь байна. Захиалагч уг мөнгөн дүнг гэрээ дүгнэсэн акт үйлдэх үед гэрээний нийт дүнгээс тооцон хасч авч үлдэнэ. Чанарын баталгааны хугацаа дуусах үед захиалагч нэгж/ashiaglagchийн санал, нийлүүлэгчийн хүсэлтээр баталгааг буцаан олгоно.</p> <p>Чанарын шаардлага хангахгүй цэвэрлэгээний материал нийлүүлсэн тохиолдолд гэрээг цуцлах үндэслэл болно.</p>
<b>ГЕН 4.17.</b>	<p>Нийлүүлэгчийн төлөх алданги:</p> <p>Алданги тооцох эсэх: “Тийм”</p> <p>Алдангийн хувь: Хугацаа хоцорсон хоног тутам гэрээний нийт үнийн дүнгийн 0,3 хувь байна.</p>
<b>ГЕН 4.18.</b>	<p>Захиалагчийн төлөх алданги:</p> <p>Алданги тооцох эсэх: “Үгүй”</p> <p>Алдангийн хувь: Байхгүй.</p>

**ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ**  
[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.  
Дугаар № [Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэрийг бичих]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэрийг бичих]** (цаашид “нийлүүлэгч” гэх) нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Бараа” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу нийлүүлэх Барааны үнэ нь **[гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дунг тоогоор болон үсгээр бичих]** төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Нийлүүлэгч **[Нийлүүлэгчийн нэрийг бичих]**-ийн харилцах **[Банкны нэрийг бичих]** банкны **[дансны дугаар бичих]** дугаар дансанд шилжүүлнэ.
3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
  - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
  - 3.2. Нийлүүлэгч тендер илгээсэн маягт;
  - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
  - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
  - 3.5. Техникийн тодорхойлолт;
  - 3.6. Бараа нийлүүлэлтийн хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
  - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл  
Эцэг/эх-ийн нэр:  
Нэр:  
Албан тушаал:  
Ажлын утас:  
Гар утас:  
Цахим шуудан:
  - 4.2. Нийлүүлэгчийн төлөөлөгчийн мэдээлэл  
Эцэг/эх-ийн нэр:  
Нэр:  
Албан тушаал:  
Ажлын утас:  
Гар утас:  
Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

## ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо: 2024 оны 10 сарын 02-ны өдөр  
Тендер шалгаруулалтын төрөл: Бараа  
Тендер шалгаруулалтын нэр: Цэвэрлэгээний материал  
Тендер шалгаруулалтын дугаар: 3TT/2024018  
Нийт төсөвт өртөг: 57,401,400.0 (тавин долоон сая дөрвөн зуун нэг мянга дөрвөн зуу) төгрөг  
Тендер шалгаруулалтын арга: Харьцуулалт

1.“Зорчигч тээвэр тав” ОНӨААТҮГ нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.

2. Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: “Багцгүй”
3. Унийн санал дуудах ажиллагаанд шаардлагатай оролцогчийн тоо: 2 болон түүнээс дээш
4. Унийн санал дуудах ажиллагаанд бүртгүүлэх журам: *Холбогдох журам*
5. Унийн санал дуудах ажиллагааг 2024 оны 10 дугаар сарын 08 өдрийн 09:05 цагт эхлүүлж, 2024 оны 10 дугаар сарын 08 өдрийн өдрийн 11:05 цагт буюу 2 (хоёр) цагийн хугацаанд зохион байгуулна.
6. Тендерийг 2024 оны 10 дугаар сарын 08 өдрийн 09:00 цагаас өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг 2024 оны 10 дугаар сарын 08 өдрийн 09:05 цагт нээнэ.
7. Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: “Зөвшөөрөхгүй”
8. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: “Эрхгүй”
9. Тендер нь түүнийг нээнээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байна.
10. Оролцогч цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо,  
Үйлдвэрийн баруун бүс ХД- 95-1, Өөрийн байранд 204 тоот Худалдан  
авах ажиллагааны алба.

Утасны дугаар: 77526666  
Цахим шуудангийн хаяг: [5.ztceever@gmail.com](mailto:5.ztceever@gmail.com)